



Хил хамгаалалтын практик

ӨНДӨР УУЛЫН БҮСЭД ХИЛ ХАМГААЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ОНЦЛОГ

Төв суурингаас алслагдсан өндөр уулын болон ой мод, намагтай хэсэгт улсын хил хамгаалалтыг зохион байгуулахдаа газар орон, цаг агаар улирлын онцлогийг онцгой анхаарах ёстой.

Газар орон, байгаль, цаг агаар, улирлын онцлог

Уулын сийрэг агаар, манан будан, аянга цахилгаантай бороо, хунгарласан цас, асга болон цасан нуранга, газар орны бартаа, ёроолгүй гүн ангал хавцал, үргэлжилсэн их намаг, битүү ой тайга, өндөр уулын түргэн урсгалтай голууд, гуу жалганд тогтсон гүнзгий цас, хунгар зэрэг нь хил хамгаалалтад онцгой хүндрэл учруулдаг. Газар орны бартаа саад, ширэнгэн ой тайга нь хяналтыг хязгаарлагдмал болгож, гагцхүү манангүй тунгалаг өдөр ой модгүй, бутлаг ургамалгүй, өндөр уулархаг хэсгүүд дээрээс үзэгдэх нөхцөл сайжирч, уулын оргилоос хяналт явуулахад өргөн уудам газар орныг харах боломжтой болдог боловч жилийн альч улиралд гэнэт бий болох үүл, үргэлжилсэн манан будан нь хилчдийн хяналт тавихад саад болж хөдөлгөөнийг удаашруулдаг онцлогтой.

Дээр дурдсан бартаа саад нь авто машин, техник хэрэгсэл явахад хүндрэл учруулахаас гадна хариуцсан хэсгээ хамгаалах, өгөгдсөн үүрэг тушаалыг хугацаанд нь биелүүлэх, хилийн зөрчлийн шинж тэмдэг илрүүлэх, хилийн эрэл явуулж, хил зөрчигчийг мөрдөн хөөж саатуулах, хуяглан хүргэх ажиллагаанд бодит бэрхшээлүүд учруулна.

Уулархаг хэсэгт тэгш тал газрыг бодвол дуу чимээ сайн сонсогддог нь хил зөрчигчийн хөдөлгөөний чиглэлийг холоос илрүүлэх боломжтой боловч ойн болон уулын гол горхины шуугиан зэрэг нь саад болно.

А. ДУЛААНЫ УЛИРЛЫН ОНЦЛОГ

Уулын голуудын усны түвшин урсгалын хурд нь цас хайлах, бороо орох зэргээс болж үргэлж огцом өөрчлөгдөнө.

Ялангуяа 5-9 дүгээр сард уулын цас хайлж голын усны түвшин өдрийн 12 цагаас эхэлж нэмэгдэнэ. Усны түвшин нэмэгдэж голууд үерлэх үед хилийн манаа голын хөндийгөөр явах, гол гатлахад онцгой аюултай болно.

Мөн өндөр уулын районд аянга цахилгаантай аадар, олон хоногоор үргэлжилсэн усан бороо орох, байнгын манан будан татах зэрэг нь хилчид аянганд өртөх, даарч осгох, төөрч будилах, үер усны аюулд нэрвэгдэхээс гадна өндөр уулын үргэлжилсэн, таг сарьдаг газруудад ундны ус, түлээ түлш олдохгүйгээс гадна хилчдийн уналгын морьд хооллох өвс ургамал ургадаггүй зэргийг анхаарах хэрэгтэй.

Уул нурууны таг, голын хөндий, ойн зах цармыг дагасан үргэлжилсэн их намаг байнга тохиолдож хилчдийн хөдөлгөөн ажиллагаанд багагүй саад учруулна.

Агаарын температур ууланд хоногийн туршид үргэлж өөрчлөгдөн хэлбэлзэж байдаг бөгөөд 200 метр өгсөх тутам агаарын температур 1 хэмээр буурч байдаг нь өндөр уулын бүсэд үүрэг гүйцэтгэж буй хилийн манааны бэлтгэлд нөлөөлөх хүчин зүйл болно.

Б. ХҮЙТНИЙ УЛИРАЛД

Цасан шуурга, үргэлжийн манан хяналтыг хязгаарлаж, хилчдийн зүгээс газар орон дээр баримжаалах явдлыг хүндрүүлэх ба чулуу, цасан нуранганд хилийн манаа өртөж болох аюултай. Өвлийн улиралд уул нурууны даваа цасанд хаагдаж аяны болон манааны жимүүд цасанд дарагдаж, хил зөрчигчийн ул мөр цасан шуурганд алга болж хилийн манаа үүрэг гүйцэтгэх, хилийн эрэл явуулах ажиллагаанд бодит хүндрэлийг учруулна.

Өндөр уулууд нь 25 хэмээс эгц хөдөрхөг уулын нуруу хяруудаар бүрдсэн байх бөгөөд 2500-3000 метрээс дээш их өндрүүд нь мөнх цас мөсөөр хучмал байхаас гадна уулын хавцлууд цасаар дүүрч, цасны зузаан нь 4-10 метр хүрэх явдал гарна.

Дээрх шалтгаан нөхцөлүүдээс болж хилийн багана тэмдгүүдийн ихэнхийг шалгах боломжгүй болдог.

Хөвсгөл аймгийн хил орчмын нутаг дэвсгэрт 9 сумын нутаг хиллэдэг ба хилийн бүсэд 224 айл, 1224 хүн 24717 толгой мал нутаглаж байна.

Хилийн бүс зурваст иргэд цөөн оршин суудаг нь хил хамгаалалтад ХЦТХ-ний гишүүд, иргэдийг өргөнөөр оролцуулах, байрлалаар нь үүрэг гүйцэтгүүлэх боломж нягтрал бага байгаа юм.

Туслах хүчний гишүүдийг хил хамгаалалтад оролцуулах талаар отряд, заставууд болон аймаг, сумдын засаг дарга, тамгын газруудаас ихээхэн анхаарал тавьж байгаа боловч иргэд хил хамгаалалтад оролцох асуудал төдийлөн хангалттай биш байна. Энэ нь хил орчмын оршин суугчид нөгөө талын иргэдтэй төрөл садангийн болон найз нөхөд танил талын холбоотой, бараг 1990 он хүртэл улсын хил гэсэн ойлголтгүй явж ирсэн нь хил зөрчин хоорондоо уулзах, нийлж ан агнах, наймаа хийх, хулгайн мал ашиглах зэрэг хууль бус үйлдлүүдийг чөлөөтэй хийдэг байсантай холбоотой юм.

Төр засгаас хойд хилийн хамгаалалтыг сайжруулах дэс дараатай арга хэмжээ авч хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулж эхэлсэн нь дээрх үйлдлүүд хийж байсан зарим этгээдийн дургүйцлийг хүргэж, тэд ч хил хамгаалах үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхийг оролдож байна.

Сүүлийн арваад жилийн хилийн зөрчлүүдийн судалгаанаас харахад манай зарим иргэд гадаадын иргэдтэй хил дээр сэм уулзаж, эд зүйл хил давуулах, хамтарч мал хулгайлах, хулгайн мал ашиглах зэрэг үйлдлүүд хийж байснаас гадна мал хариулгагүй байлгаж хил давуулчихаад хилчид хилээ хамгаалсангүй гэж хилчдийн нэр хүндийг ард түмний дунд унагаах явуулга хийж байгаа нь ажиглагддаг.

Үүнээс гадна хил хамгаалалтад оролцож байгаа иргэдийг Хилийн тухай хуульд заасан үүрэг гүйцэтгэх үеийн хүнс уналга, шатахууны зардлыг олгож чадахгүй байгаагаас тэдний идэвхи сонирхол сул, хилийн хуулийн заалт биелэхгүй байна.

Хил залгаа улсын хамгаалалтын онцлог

Хариуцсан хэсгийн эсрэг талд ойр төв суурин газар айл ховор боловч сүүлийн жилүүдэд ОХУ-ын Тувагийн талтай хиллэдэг хэсэгт хил дамнасан малын хулгай, Буриадын хэсэгт хил зөрчиж ан хийх, хууль бусаар эд зүйл наймаалах зөрчил нэмэгдсээр байна.

1994 онд 2 удаа 7 толгой, 1995 онд 3 удаа 82 толгой, 1996 онд 3 удаа 143 толгой, 1997 онд 4 удаа 172 толгой, 1998 онд 5 удаа 178 толгой мал хил давж алдагдаад байгаа нь малын хулгай өсөж байгаагийн нэг жишээ юм.

Сүүлийн үед малын хулгайчдын үйл ажиллагаа улам бүр

дээрмийн шинжтэй болж хилийн бүс зурвас төдийгүй, түүнээс ч гүнд орж мал хулгайлж байгаагаас гадна хил зөрчигчид хилчдийн эсрэг шууд зэвсэг хэрэглэх боллоо.

Оросын талын Хилийн Бүрэн Эрхт Төлөөлөгчид нь Ханх-Мондын ШНБ-оос бусад газар авто тээврийн хэрэгслээр хил дээр хүрэлцэн ирэх зам харгүй байхгүй гэдэг шалтгаар хилийн зөрчлийн асуудлыг шийдвэрлэхэд идэвхигүй хандаж байна.

Оросын талаас хил хамгаалахад анхаарал сул тавьдагаас хил хамгаалалтад төдийлөн үр дүн гарахгүй, хил зөрчсөн гадаадын иргэдийн тоо улам бүр нэмэгдсээр байна.

Оросууд эдийн засгийн хүндрэлээс шалтгаалж манай улстай хил залгаа хэсгээ хамгаалж чадахгүй байна гэж тайлбарлаж байгаа боловч энэ нь цаанаа үндэс угсаа нэгтэй Монгол туургатнуудыг эв эегүй байлгах, хил хязгаарыг эзэнгүйдүүлэх зэрэг их гүрний бодлого оршиж байхыг үгүйсгэх аргагүй юм.

Алслагдсан хэсгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь

Төв суурин газар хилийн засталаас алслагдсан хэсгийн хил хамгаалалтыг тавигдаж буй шаардлагын хэмжээнд явуулахын тулд хариуцсан хэсэгт инженер техникийн ажлыг нэн тэргүүнд хийж гүйцэтгэх нь зүйтэй.

Хилийн засталаас улсын хил хүртэл авто замыг барьж байгуулснаар заставуудыг хилд ойртуулан нүүлгэн шилжүүлэх, шинээр хилийн застав, харуулыг нэмж байгуулж хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх боломжийг олгохоос гадна автомашинаар харуулын бие бүрэлдэхүүнийг байрлал дээр нь хүргэх, хүч хэрэгслийг богино хугацаанд шилжүүлэн байрлуулах, уналгын морьдын эдэлгээг сайжруулах зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх үндсэн нөхцөл бүрдэх юм.

Улсын хилийн тодорхой хэсгийг ямар хүч хэрэгслээр хамгаалбал зохих ёстойг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, хариуцсан хэсгийн 1 км бүрт нэг хилчинд оногдож байх тооцоонд үндэслэн хилийн отряд, заставын санхүүгийн эх үүсвэрийн үндсийг тогтоож байх нь зөв байна.

Хил хамгаалалтын туршлагаас үзэхэд хилийн отряд 500 км, хилийн застав 40-50 км, харуул 20-25 км-ээс илүүгүй хэсгийг хариуцан хамгаалдаг байх нь тохиромжтой юм.

Хил хамгаалалтыг зохих түвшинд явуулахын тулд хилийн заставын орон тоог 50 хүн хүртэл нэмэгдүүлж, хүн нэг бүрийн үүрэг гүйцэтгэх ачааллыг хууль дүрмэнд зааснаас хэтрүүлэхгүй байвал зохино.

Хилчин нэг бүрийг 5-6 морьтой байлгахын тулд хилийн заставыг 200-аас доошгүй уналгын морьтой болгох шаардлагатай байна. Уналгын морьд хүрэлцээгүйгээс заставуудад хүн нэмж авах, отрядын бэлтгэл хүчнээс бүлгүүдийг хилд томилж ажиллуулахад хүндрэлтэй байгаа юм.

Хөвсгөлийн хилийн отрядын хариуцсан хэсгийн хамгаалалтыг найвдартай болгох эрх ашигт нийцүүлэн одоогийн отрядын харьяа 2 комендатурыг Хордил Сарьдагийн нуруугаар зааглаж хоёр хэсэгт хуваан хариуцуулах нь зүйтэй.

Комендатурын дарга нь Хилийн Бүрэн эрхт Төлөөлөгчийн орлогч албан тушаалтай байх ба комендатур нь хилийн застав дээр байрлах нь зохистой юм.

Хилийн цэрэг өөрөө тагнуулын албатай байсан уламжлалыг дахин сэргээж, хилийн отрядуудад тагнуулын болон хэрэг бүртгэлийн албыг бий болгож отрядын даргад захируулах нь илүү үр дүнтэй болох юм.

Мөн Монгол улсын хил хамгаалалтын талаархи хууль тогтоомжуудад зарим нэг өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Монгол Улсын Хилийн тухай хуульд "Хил хамгаалалт нь хилийн цэргээс хилийн бүс зурваст явуулж байгаа үйл ажиллагаа" гэж тодорхойлон хилийн бүсийг 30 км, зурвасыг 5 км-ээс илүүгүйгээр тогтоосон нь өндөр уул ой мод, намагтай алслагдсан хэсгийн хил хамгаалалтад тохиромжгүй байна. Ийм нөхцөлд хилийн цэргийн үйл ажиллагаа ихэвчлэн хилийн бүс зурвас, түүний гүнд явагдаж байгаа билээ.

Иймээс хилийн бүс зурвасын өргөнийг "Тухайн хил хамгаалах байгууллагын саналыг үндэслэн орон нутгийн төрийн захиргааны байгууллага тогтоож байхаар" хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй. Мөн дээрх хуулийн 37 дугаар зүйлд заасан зэвсэг хэрэглэх журмын урьдчилан анхааруулахгүйгээр зэвсэг хэрэглэх тохиолдолд "Хил зөрчигч зэвсэг хэрэглэх шинж тэмдэг бодитойгоор илэрсэн үед" гэсэн заалт нэмж оруулах нь хилчдийн эрх ашигт нийцэж байна.

Улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангахын тулд орчин үеийн техник хэрэгслийг өргөн ашиглах хилийн заставын бэлтгэл хүчийг тээвэрлэх, алслагдсан хэсэгт богино хугацаанд хүрч очих, хилийн эрлийн үед болон бүслэн авах бүлгүүдийг нэг зэрэг үүрэг

гүйцэтгэх зааг дээр нь хүргэх, хилийн харуулыг байрлал дээр нь халалцуулах зорилгоор хилийн заставуудыг бага даацын ачааны болон суудлын автомашин, мотоцикл, цасны моторт чарга, завь, цаа бугаар хангах шаардлагатай юм.

Хүрэхэд хүндрэлтэй алслагдсан хэсгүүдэд хүч хэрэгслийг зөөх, хилийн багана тэмдгүүдийг шалгах, агаараас хяналт хийхэд нисдэг тэргийг ашиглах, цаашдаа хилийн цэргийн нэгжүүдийг бага оврын нисдэг тэрэгтэй болгох зайлшгүй шаардлагатай.

Хилийн застасаас алслагдсан хэсэгт үүрэг гүйцэтгэж байгаа хилийн харуулыг хөнгөн жинтэй бага оврын богино долгионы радио станцаар хангах нь хамгийн тохиромжтой байна. Өнөөдөр хилийн цэрэгт хэрэглэгдэж байгаа СВХ-11А радиостанц нь авч явахад тохиромжтой, тэжээл бага хэрэглэдэг зэрэг үзүүлэлтээрээ хилийн харуул, манаанд хэрэглэхэд тохиромжтой байгаа тул сансарын холбооны системд шилжих хүртэл дээрх станцаар хилийн застав харуулуудыг хангах нь зүйтэй юм. Хилийн харуул манааны холбооны тэжээлийг цэнэглэхэд нарны эрчим хүчээр ажилладаг бага оврын цэнэглэгч онцгой тохирч байна.

Өндөр уулын болон ой, намагтай алслагдсан хэсэгт хамгаалалтыг оновчтой зохион байгуулах гол хэлбэр нь улсын хилийг харуулаар хамгаалах явдал юм.

Хилийн заставын хариуцсан хэсэгт 3-4 харуулын байр барьж тохижуулан эдгээр харуулын байруудад 10-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй хүчжүүлсэн харуулыг нэгээс нөгөөд нь шилжүүлэн нэг байранд 5-6 хоногоор үүрэг гүйцэтгүүлэх, эсвэл 2-оос доошгүй байнгын хянах харуулыг 10-20 хоногоор томилж байрлал дээр нь халалцуулан үүрэг гүйцэтгүүлэх нь тохиромжтой.

Заставын дарга 10-20 хоногийн дотор цагийн байдал өөрчлөгдөх, байгаль цаг уурын гэнэтийн бэрхшээлийг урьдчилан мэдэх, харуултайгаа байнга холбоо барих бололцоогүй байдаг учир харуулын дарга шийдвэр гаргах эрхтэй байхаар хил хамгаалалтын дүрмэнд өөрчлөлт оруулах хэрэгтэй байна.

Хилийн харуул манаа алслагдсан хэсэгт олон хоногоор үүрэг гүйцэтгэж, улсын хил хамгаалах үүргээ амжилттай биелүүлэх нь хилчин нэг бүрийн урьдчилсан бэлтгэл, сэтгэл зүйн болон бие бялдар, эрүүл мэнд, албаны мэдлэг, дадлага, чадвараас шууд хамаардаг. Олон хоногоор улсын хил амжилттай үүрэг гүйцэтгэхийн нэг нөхцөл нь хилийн харуул манааны бэлтгэлийг сайтар хангах явдал юм. Харуулын шууд бэлтгэлийг 7 хоногийн өмнө эхлэх нь зохимжтой байдаг. Харуулын бэлтгэлийг хангах явцад хүнс, чухал эм тариа,

ороох боох материал, дулаан хувцас зэрэгт онцгой анхаарахаас гадна их хэмжээний ачиллагатай явдаг тул хөтөлгөө морийг сургаж бэлтгэсэн байх нь зүйтэй.

Хилчдийн сургалт, соёл хүмүүжлийн ажлыг хилийн застав дээр төлөвлөсөн программын дагуу зохион байгуулж, онолын мэдлэг олгохоос гадна улсын хилд албан үүрэг гүйцэтгэх явцад нь тэдний дадлага чадвар, тэсвэр хатуужил, хүмүүжлийг дээшлүүлэхийг чухалчлах хэрэгтэй. Мөр судлалд мэргэжих, унаа, морио зөв эдэлж хэрэглэж сурах, хүйтэнд тэсвэрлэх, газар орноо судлах, мэргэн буудах, нойр хоолгүйдэж ядрахгүй байх чадвараа хилчид уул тайгын нөхцөлд үүрэг гүйцэтгэх бүрдээ сайжруулж байдаг.

Хилийн манааны тохироог бүрдүүлэхдээ дадлага туршлагатай хилчдийг шинээр албанд ирсэн цэргийн албан хаагчидтай тэнцүү тоотой хуваарилан үүрэг гүйцэтгүүлэх нь тохиромжтой. Хилийн застав харуулд бүх төрлийн хангалтыг сайтар зохион байгуулахаас гадна хилчдийн эрүүл мэнд, ар гэрийн амьдралыг халамжилж байх нь хилчид ар талдаа сэтгэл зоволтгүй, албаа үнэнч шударга идэвхи зүтгэлтэй хаах боломжийг бүрдүүлдэг.

Хилийн эрэл явагдаж байгаа үед хилчдийн бие дааж ажиллах чадвар маш чухал байдаг. Хилийн застасаас алслагдсан өндөр уул, ой модтой хэсэгт гарсан хилийн зөрчлийн судалгаанаас үзэхэд хилийн зөрчлийн 38 хувь нь хилийн манааны хяналтаар илэрч, 62 хувь нь зөрчсөн ул мөрийг илрүүлж, эрэл зохион байгуулсны дүнд саатуулагджээ.

Дээрх үзүүлэлтээс харахад хариуцсан хэсэгт хил хамгаалалтын үндсэн арга нь цэргийн хяналт, газар оронд үзлэг шалгалт хийх гэдэг нь тодорхой байна.

Цэргийн хяналтыг харуулын байрнаас гадна хамгаалалтын I, II, III заагуудад тусгайлан төхөөрөмжилж, тохижуулсан ил болон далд хянах байруудаас явуулахаас гадна хилийн манааны маршрутыг сонгохдоо аль болох хяналт явуулах бололцоотой уулын ус хагалбарыг ашиглан тогтоох нь зүйтэй.

Сэргийлэх манааг хил зөрчигч явж нуугдаж, байрлаж болзошгүй газрууд уулын даваа, голын гарам, зам харгуй зэрэг газруудаар үүрэг гүйцэтгүүлэх нь хилийн зөрчлийн ул мөр, шинж тэмдгийг цаг тухайд нь илрүүлэх боломжийг бүрдүүлдэг. Мөн шөнө ан амьтны марааны дэргэд нууц манаа томилох, өндөрлөг газраас ил гал илрүүлэх зорилгоор хяналт тавих нь оновчтой.

Алслагдсан их урт хилийн хэсэгт хил зөрчигчийг илрүүлсэн даруйдаа бүслэн хааж мөрдөж саатуулах нь маш хүндрэлтэй, бараг

бололцоогүй зүйл байдаг. Иймд хил зөрчигчдийг түрүүлж илрүүлэн харилцан ажиллагааг сайтар зохион байгуулах, газар орноо сайн мэдэх давуу талаа ашиглан зөрчил гаргагчдыг гэнэт саатуулах нь оновчтой байдаг.

Монгол Улсын хойд хилийн 26 хувийг хариуцдаг Хөвсгөлийн отрядын хэсэгт улсын хөрөнгө оруулалтаар дэд бүтцийг хөгжүүлэх, хилийн заставуудыг шинээр барьж байгуулах, нүүлгэн шилжүүлж хилд нь ойртуулах арга хэмжээг ойрын үед авч улсын хил хамгаалалтыг эрс сайжруулах шаардлагатайг төр засаг яам, командлал анхаарах нь зүйтэй.

Төв суурингаас алслагдсан өндөр уулын болон ой мод, намагтай хэсэг дэх заставын хил хамгаалалтыг цаашид гүнзгийрүүлэн тусгайлан судалж, шинжлэх ухааны үндэстэйгээр боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна.

*Монгол Улсын хилийн Хөвсгөлийн хэсгийн
Бүрэн Эрхт Төлөөлөгч, хилийн отрядын дарга,
хурандаа Д.Болдбаатар*